



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/02

Хужирт сум

Насан туршийн боловсролын "Дүйцсэн хөтөлбөр"-ийн сургалт явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсрол, Соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/168 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам"-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсрол, соёлын газрын дүгнэлтийг үндэслэн сургууль завсардсан, Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй сургуулийн насны болон суурь, бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлтэй иргэдэд насан туршийн боловсролын "Дүйцсэн хөтөлбөр"-ийн сургалтыг зохион байгуулж явуулсугай.

2. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан Ерөнхий боловсролын сургуулийн захирлаар батлуулан хэрэгжүүлж ажиллахыг Насан туршийн боловсролын нэгжийн багш, арга зүйч (Д.Давга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301005
D:Alban bichig,Zahiramj 2023